



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/167

Хэрлэн сум

Архи, согтууруулах ундаа
худалдах, түүгээр үйлчлэхийг түр
хугацаагаар хориглох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", "л", 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 63 дугаар зүйлийн 63.1, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1, 14.3.2, 14.3.4, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1. дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт архинд хордож нэг иргэн нас барсан, цаашид гүн хордлогод орсон иргэдийн тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан 2017 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн шалтгаан нөхцөлийг тогтоох хүртэл түр хугацаагаар аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд архи, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.

2. Архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчилдэг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах, архинд хордсон шалтгаан нөхцөлийг шалгаж тогтоох талаар арга хэмжээ авч аймгийн удирдлагуудыг мэдээллээр хангаж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, /Цагдаагийн хурандаа О.Ганбат/, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Б.Сүнгээ/ нарт, харьяалах сум, тосгоны нутаг дэвсгэрийн хэмжээнд хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга, тосгоны Захирагч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА